

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 10 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 279

Улаанбаатар хот

Г “Буянт төв” ХК-ийн үнэт цаасыг Ү  
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам”-ын 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Буянт төв” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 150 766 ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжаас хасахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Компанийн зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилж байгаатай холбогдуулан хуулиар хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Буянт төв” ХК /Ж. Саруул/-д үүрэг болгосугай.

3. Энэ тухай Улсын бүртгэлийн ерөнхий газарт 10 хоногийн дотор мэдэгдэж тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН